[25] D DOI: 10.65902/tsats.2026.01.002 Experience and Lessons from Human security in the cyber environment: Risks and key protection issues
[26] Kaspersky. (2022, November 23). What is cyber immunity and how to build an operating system based on the concept. Kaspersky Blog. https://www.kaspersky.com/blog/how-to-create-cyberimmune-system/46314/
Wlodarczak, P. (2017). Cyber immunity. In I. Rojas & F. Ortuño (Eds.), Bioinformatics and biomedical engineering (Lecture Notes in Computer Science, Vol. 10209, pp. 1–9). Springer. https://doi.org/10.1007/978-3-319-56154-7_19

Касперскийн лабораторийн үндэслэгч Евгений Касперский кибер дархлааг *"Кибер дархлааны систем гэдэг нь аюулгүй байхаар зохиогдсон, халдлагад өртсөн ч үндсэн үүргээ гүйцэтгэсээр байдаг систем юм*[27]*"* гэж тодорхойлсон.

Биологийн дархлаатай харьцуулж үзвэл:

Кибер дархлааны үзэл баримтлал нь биологийн дархлааны системтэй олон талаараа төстэй:

*1 дүгээр хүснэгт*

| Д/д | Биологийн дархлаа | Кибер дархлаа |
|---|---|---|
| 1 | Вирус, бактери илрүүлэх | Хортой код, халдлага илрүүлэх |
| 2 | Эсрэг бие үүсгэх | Хамгаалалтын дүрэм боловсруулах |
| 3 | Дархлааны санах ой | Халдлагын мэдээллийн сан |
| 4 | Өөрийгөө сэргээх | Системийг автоматаар сэргээх |
| 5 | Гадны биетийг таних | Хэвийн бус байдал илрүүлэх |

Кибер дархлааны системүүд дараах үндсэн зарчмуудад тулгуурладаг:

1. *Төрмөл аюулгүй байдал*: Систем зохиогдох үеэс нь аюулгүй байдлыг хангах зарчим бөгөөд үндсэн бүтцэд нь суулгасан байдаг;

2. *Хамгийн бага эрх*: Системийн бүрэлдэхүүн хэсэг бүр зөвхөн өөрийн үүрэгт шаардлагатай хамгийн бага эрхтэй байх зарчим;

3. *Тусгаарлалт*: Системийн нэг хэсэгт халдлага гарсан ч бусад хэсэгт нөлөөлөхгүй байхаар тусгаарладаг;

4. *Тасралтгүй хяналт*: Системийн үйл ажиллагааг тасралтгүй хянаж, хэвийн бус үйлдлийг илрүүлдэг;

5. *Дасан зохицох чадвар*: Шинэ төрлийн халдлагад дасан зохицож, хамгаалалтаа автоматаар шинэчлэх чадвар гэж үзэж болно.

*Кибер дархлаа сул байх үр дагавар:* Кибер дархлаа сул байх нь зөвхөн техникийн асуудал биш бөгөөд улс орны нийгэм, эдийн засаг, улс төрийн олон салбарын хүрээнд нөлөөлдөг нарийн төвөгтэй үзэгдэл юм. Энэхүү сул байдлыг ашиглах сонирхолтой этгээдүүд хувь хүн, байгууллага, улсын түвшинд тус тусын зорилгоор үйл ажиллагаа явуулдаг байна.

*Хувь хүний түвшинд:* Хувь хүний кибер дархлаа сул байх нь хүний хувийн мэдээллийн аюулгүй байдалд шууд нөлөөлдөг. Орчин үеийн дижитал орчинд хувь хүн өдөр тутмын үйл ажиллагаандаа цахим банк, нийгмийн сүлжээ, цахим худалдаа зэрэг олон төрлийн мэдээллийн системийг ашигладаг болсон. Энэхүү хамаарал нэмэгдэхийн хэрээр кибер халдлагын эрсдэл ч нэмэгдэж байна. Мөн халдагч этгээдүүд фишинг, нийгмийн инженерчлэл (social engineering), хортой программ зэрэг аргуудыг ашиглан хувийн мэдээлэл, санхүүгийн эрхийг хулгайлах боломжтой болдог. Үүний үр дүнд хувь хүн санхүүгийн хохирол амсахаас гадна нэр төрөө унагаах, хувийн нууцаа алдах эрсдэлд өртдөг байна. Судалгаануудаас харвал кибер халдлагын улмаас хувь хүний хохирол жил ирэх тусам өсөн

[27] Kaspersky, E. (2021, November 12). Transition from cybersecurity to cyber-immunity. IRISSCON 2021. Infosecurity Magazine. https://www.infosecurity-magazine.com/news/transition-cyber-immunity-kaspersky/

нэмэгдэж байгаа бөгөөд энэ нь кибер дархлааг бэхжүүлэх шаардлагыг улам тодорхой болгож байна.

Байгууллагын түвшинд: Байгууллагын түвшинд кибер дархлаа сул байдал нь өрсөлдөгч байгууллага болон кибер гэмт хэрэгтнүүдэд давуу тал олгодог. Байгууллагын мэдээллийн системд нэвтрэх боломж олдсон халдагч этгээд нь үйлчлүүлэгчдийн мэдээллийн сан, оюуны өмч, санхүүгийн мэдээлэл зэргийг хулгайлах эсвэл ransomware буюу хортой программ ашиглан байгууллагын үйл ажиллагааг бүхэлд нь саатуулж мөнгөн төлбөр нэхэх боломжтой болдог. Энэ төрлийн халдлага нь байгууллагад санхүүгийн шууд хохиролоос гадна хэрэглэгчдийн итгэлцлийг алдах, зах зээлд эзлэх байр сууриа сулруулах зэрэг урт хугацааны сөрөг үр дагавар авчирдаг. Дэлхийн хэмжээнд томоохон корпорациуд кибер халдлагын улмаас хэдэн арван сая долларын хохирол амсаж байгаа нь байгууллагын кибер дархлааг бэхжүүлэх нь стратегийн зайлшгүй шаардлага болсныг харуулж байна.

Улсын түвшинд: Улсын түвшинд кибер дархлааны сул байдал нь улс үндэстний үндэсний аюулгүй байдалд шууд нөлөөлөх чадвартай. Гадаад орны тагнуулын байгууллага болон дайсагнасан улс орнуудын кибер нэгжүүд нь сул хамгаалалттай дэд бүтцийг ашиглан засгийн газрын нууц мэдээлэл олж авах, цахилгаан хангамж, харилцаа холбоо, санхүүгийн системд халдах бүрэн боломжтой болдог.

Кибер дархлаа сул байгаа улс орнуудын хувьд эдгээр эрсдэл нь зөвхөн технологийн асуудал биш, харин улс төр, эдийн засгийн тогтвортой байдалд нөлөөлөх стратегийн аюул болж хувирдаг. Иймд олон улсын судлаачид кибер дархлааг үндэсний аюулгүй байдлын бодлогын салшгүй хэсэг болгон авч үзэх шаардлагатайг онцолж байна.

**Судалгааны хэсэг:** Кибер халдлагын дэлхийн статистик, жишээ.

Орчин үеийн дижитал орчинд кибер халдлагын тоо жил ирэх тусам эрс нэмэгдэж байна. Check Point Research-ийн судалгааны дүнгээр 2024 оны гуравдугаар улиралд дэлхий даяар нэг байгууллагад долоо хоногт дунджаар 1,876 кибер халдлага бүртгэгдсэн нь 2023 оны мөн үетэй харьцуулахад 75 хувиар өссөн үзүүлэлт юм[28]. Энэ нь кибер халдлагын өсөлтийн хандлага тасралтгүй үргэлжилж байгааг тодорхой харуулж байна.

Санхүүгийн хохирлын хувьд 2024 онд дэлхий даяар кибер гэмт хэргийн улмаас учрах хохирол 9.5 их наяд ам.доллард хүрэхээр тооцогдсон бөгөөд энэ үзүүлэлт 2025 он гэхэд 10.5 их наяд ам.долларт хүрнэ гэж Cybersecurity Ventures таамаглаж байна[29]. Мөн нэг өгөгдлийн зөрчлийн дундаж зардал 2024 онд 4.88 сая

[28] Check Point Research. (2024). A closer look at Q3 2024: 75% surge in cyber attacks worldwide. Check Point Blog. https://blog.checkpoint.com/research/a-closer-look-at-q3-2024-75-surge-in-cyber-attacks-worldwide/
[29] Cobalt. (2024). Top cybersecurity statistics for 2024. https://www.cobalt.io/blog/cybersecurity-statistics-2024

ам.доллар болж, өмнөх оноос 10 хувиар өссөн байна[30]. Кибер халдлагын дэлхийн статистик үзүүлэлтүүд

*1 дүгээр график*




Салбарын хувьд боловсрол, судалгааны байгууллагууд долоо хоногт дунджаар 3,828 халдлагад өртдөг хамгийн эрсдэлтэй салбар болоод байгаа бөгөөд засгийн газар, цэргийн байгууллага болон эрүүл мэндийн салбар түүнийг дагаж байна. Ransomware буюу хортой программын халдлагын хувьд 2024 оны гуравдугаар улиралд 1,230 гаруй тохиолдол бүртгэгдсэн бөгөөд хохирогчдын 57 хувь нь Хойд Америкт төвлөрчээ[31].

*2 дугаар график*




[30] SentinelOne. (2024). Key cybersecurity statistics. https://www.sentinelone.com/cybersecurity-101/cybersecurity/cyber-security-statistics/

[31] Check Point Research. (2024). A closer look at Q3 2024: 75% surge in cyber attacks worldwide. Check Point Blog. https://blog.checkpoint.com/research/a-closer-look-at-q3-2024-75-surge-in-cyber-attacks-worldwide/

*Дэлхийн улс орнуудын кибер дархлааны өнөөгийн байдал.*

Кибер дархлааны үзэл баримтлал нь онолын хүрээнээс гарч практик хэрэглээнд нэвтрэх болсон нь орчин үеийн кибер аюулгүй байдлын салбарын чухал хөгжил юм. Үйлдвэрлэлийн интернет (Industrial Internet of Things-IIoT) болон Industry 4.0-ийн хүрээнд мэдээллийн технологи болон үйлдвэрлэлийн технологийн нэгдэл нь кибер халдлагын талбарыг эрс нэмэгдүүлж, уламжлалт кибер аюулгүй байдлын хамгаалалтын хязгаарлагдмал байдлыг илрүүлсний үндсэн дээр кибер дархлааны шинэ үзэл баримтлал бий болсон байна[32].

Дэлхийн улс орнуудын кибер дархлаа практик хэрэглээний тэргүүлэх жишээ бол Касперскийн лабораторийн боловсруулсан KasperskyOS үйлдлийн систем юм. Кибер дархлааг хэрэгжүүлэх үндсэн арга нь мэдээллийн системийг тусгаарлагдсан хэсгүүдэд хуваах, тэдгээрийн харилцан үйлчлэлийг хянах зарчимд тулгуурладаг бөгөөд ийм системд учрах ихэнх халдлага үр дүнгүй болж, систем нь дайсагнасан орчинд ч үндсэн үүргээ гүйцэтгэсээр байна[33].

Аж үйлдвэрийн салбарт кибер дархлааны хэрэглээ онцгой ач холбогдолтой болж байна. Netflix компани өөрийн системийг санаатайгаар эвдэрч унагах "chaos engineering" аргачлалыг ашиглан эмзэг байдлыг илрүүлж, агшин зуур дасан зохицож, өөрөө сэргээгддэг дэд бүтцийг бий болгосон нь кибер дархлааны системийн практик хэрэгжилтийн нэг томоохон жишээ болжээ [34] . Кибер дархлааны системийн дэлхийн зах зээл 2022 онд 16.8 тэрбум амдоллар байснаас 2032 он гэхэд 57 тэрбум амдолларт хүрнэ гэж судлаачид таамаглагдаж байна[35].

*Монгол Улсын кибер аюулгүй байдлын өнөөгийн байдал:* Монгол Улсын кибер аюулгүй байдлын түвшинг олон улсын хэмжээнд үнэлэхэд ITU-ийн Дэлхийн кибер аюулгүй байдлын индекс (GCI) чухал үүрэг гүйцэтгэдэг. GCI 2024 тайлангаар Монгол Улс 56.36 оноо авч, 194 орноос 103 дугаарт буюу "Бэхжиж буй" (Establishing) гэсэн 3 дугаар түвшинд үнэлэгдсэн нь 2020 оны 26.20 оноотой харьцуулахад 17 байр урагшилсан үзүүлэлт юм[36].

Тулгуур хэмжигдэхүүн бүрээр авч үзвэл Монгол Улс хууль эрх зүй, бүтэц зохион байгуулалт, чадавх бэхжүүлэлтийн хувьд эрчимтэй өсөлт үзүүлж, Ази Номхон далайн бүс нутгийн дундаж үнэлгээг хангасан байна.

Хууль эрх зүйн орчны хувьд Монгол Улс 2021 оноос хойш Кибер аюулгүй байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон тэдгээрийг дагалдан гарах дүрэм, журмуудыг баталж хууль эрх зүйн орчныг

[32] Butt, U. A., Amin, R., Aldabbas, H., Garg, S., Alroobaea, R., & Almotiri, S. H. (2021). Industrial IoT, cyber threats, and standards landscape: Evaluation and roadmap. PMC/NCBI. https://pmc.ncbi.nlm.nih.gov/articles/PMC8200965/

[33]Kaspersky Lab. (2025). What is cyber immunity? Kaspersky IT Encyclopedia. https://encyclopedia.kaspersky.com/glossary/cyberimmunity/

[34] Software Engineering Institute. (2024). DevOps case study: Netflix and the Chaos Monkey. Carnegie Mellon University. https://www.sei.cmu.edu/blog/devops-case-study-netflix-and-the-chaos-monkey/

[35] Allied Market Research. (2023). Digital immune system market size, share, competitive landscape and trend analysis report: Global opportunity analysis and industry forecast, 2023–2032. https://www.alliedmarketresearch.com/digital-immune-system-market-A77311

[36]International Telecommunication Union. (2024). Global Cybersecurity Index 2024. ITU. https://www.itu.int/epublications/publication/global-cybersecurity-index-2024

тасралтгүй сайжруулсан нь GCI-ийн хууль эрх зүйн үзүүлэлтийн дээд оноонд ойртсоныг илэрхийлж байна[37]. Гэсэн хэдий ч кибер халдлагын тоо, хохирлын хэмжээ өсөн нэмэгдэж байгаа нь анхаарал татаж байна. Сүүлийн таван жилийн хугацаанд төр захиргаа, олон нийтийн байгууллага, хувийн хэвшил, иргэнийг үл харгалзан кибер халдлагад өртсөн тохиолдол 25,849-д хүрч, 2023 онд учирсан хохирол 87.5 тэрбум төгрөгт хүрсэн байна[38]. Монгол Улсад долоо хоногт 90 гаруй мянган кибер халдлага, зөрчлийн тохиолдол илэрдэг бөгөөд 2023 онд долоо хоногт дунджаар 38 компанийн 8,699 IP хаягт 91,788 удаагийн сэжигтэй хандалт илэрсэн байна[39]. Техникийн чадавхын хувьд 2024 онд Монгол Улсад 184,576 IP хаяг бүртгэлтэй байгаагийн 11,012 IP хаягт сэжигтэй үйлдэл илэрч, 90 орчим тэрбум төгрөгийн хохирол учруулж, 145 IP хаягт хариу арга хэмжээ авсан байна[40]. Институцийн чадавхыг бэхжүүлэх чиглэлд 2023 онд кибер халдлага, зөрчилтэй тэмцэх үндэсний болон нийтийн төвүүд байгуулагдаж, улсын хэмжээнд төр, иргэн, хуулийн этгээд кибер халдлагад өртсөн тохиолдолд мэргэжлийн дэмжлэг авах боломж бүрдсэн байна[41].

*2 дугаар хүснэгт*

| Он | Үзүүлэлт | Учруулсан хор хохирол | Сэжигтэй хандалтын тоо |
|---|---|---|---|
| 2023 | Сэжигтэй хандалт | 87.5 тэрбум төгрөг | 91.788 |
| 2024 | Сэжигтэй хандалт | 90 орчим тэрбум төгрөг | 11.012 |

Цаашдын чиглэлийн хувьд Монгол Улс Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хамтран кибер аюулгүй байдлын хүний нөөцийг чадавхжуулах техникийн хамтын ажиллагааны төслийг хэрэгжүүлж, Оксфордын их сургуулийн эрдэмтэдтэй хамтран кибер аюулгүй байдлын өнөөгийн түвшнийг үнэлэх судалгааг явуулж байна[42].

[37]Монгол Улсын Их Хурал. (2021а). Кибер аюулгүй байдлын тухай хууль. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390365491061
Монгол Улсын Их Хурал. (2021б). Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль. https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/2024-04/biznesiyn_bayguullaguudad_zoriulsan_garyn_avlaga.pdf
[38] Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам. (2024, 10-р сарын 10). Кибер гэмт хэргийн улмаас 87.5 тэрбум төгрөгийн хохирол учирчээ. https://mddc.gov.mn/eng/2024/10/19291/
[39] Золбаяр, Ч. (2024, 1-р сарын 15). Долоо хоногт Монголд 90 гаруй мянган кибер халдлага илэрдэг. itoim.mn. https://itoim.mn/a/2024/01/15/society/yek
[40] Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам. (2025, 1-р сарын 29). 2024 онд хортой кодын халдлагад өртсөн 145 IP-т хариу арга хэмжээ авчээ. https://mddic.gov.mn/eng/2025/01/20833/
[41] Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх үндэсний төв. (2023). Бидний тухай. https://ncsirt.gov.mn/p/3Монгол Улсын Засгийн газар. (2023, 8-р сарын 30). "Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв" улсын төсөвт үйлдвэрийн газар байгуулах тухай (Тогтоол № 319). https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760334026011
[42] Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам. (2024а, 9-р сарын 18). Кибер аюулгүй байдал, дроны мэргэжилтнүүдийг бэлдэх чиглэлд ЖАЙКА-тай хамтран ажиллана. https://mddc.gov.mn/mn/2024/09/18657/
Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам. (2025, 2-р сарын 19). Oxford: Монгол Улс кибер аюулгүй байдлыг хангах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай. https://mddic.gov.mn/eng/2025/02/21011/

*Кибер дархлааны хамгаалалтын механизмууд:*

Кибер дархлааны хамгаалалтын механизмууд нь уламжлалт аюулгүй байдлын арга хэмжээнүүдээс эрс ялгаатай зарчимд тулгуурладаг. Уламжлалт үйлдлийн системүүд суурь давхарга, аппликейшны давхарга, аюулгүй байдлын давхарга гэсэн гурван түвшний бүтэцтэй бөгөөд аюулгүй байдлын давхарга зөрчигдвөл халдагч этгээд доод давхаргуудад нэвтэрч, системийн үйл ажиллагааг бүхэлд нь удирдах боломжтой болдог.

Касперскийн лабораторийн KasperskyOS үйлдлийн систем нь кибер дархлааны хамгаалалтын механизмыг практикт хэрэгжүүлсэн тэргүүлэх жишээ юм. Кибер дархлааны системийн бүрэлдэхүүн хэсэг бүр бие биенээсээ болон гадаад орчноос бүрэн тусгаарлагдсан байдаг бөгөөд ямар нэгэн хяналтгүй харилцан үйлчлэлийг бүрэн арилгадаг. Системийн бүрэлдэхүүн хэсгүүдийн хоорондын мэдээллийн урсгал нь аюулгүй байдлын бодлогод нийцэж байгаа эсэхийг тасралтгүй шалгадаг бөгөөд системийн чухал хөрөнгө, функцид шууд нөлөөлдөг итгэмжлэгдсэн кодын хэмжээ хамгийн бага байхаар тохируулагддаг[43].

Хиймэл оюуны болон машин сургалтын технологи кибер дархлааны системийг улам боловсронгуй болгоход чухал үүрэг гүйцэтгэж байна. Хиймэл оюун ухаан болон машин сургалт нь эмзэг байдлыг эрт илрүүлэх, таамаглахад туслан байгууллагуудад болзошгүй кибер аюулаас урьдчилан хамгаалах идэвхтэй арга хэмжээ авах боломж олгодог. Gartner-ийн таамаглалаар 2025 он гэхэд цахим дархлааны системд хөрөнгө оруулалт хийсэн байгууллагуудын зогсолтын хугацаа 80 хувиар буурах бөгөөд энэ нь хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг мэдэгдэхүйц нэмэгдүүлэхэд хүргэнэ[44].

Орчин үеийн кибер аюулгүй байдлын чиг хандлагын хувьд таних мэдэрхүйний дархлааны систем буюу identity fabric immunity нь таних мэдэрхүйний системийг идэвхтэй болон хариу үйлдлийн аргаар хамгаалах, кибер аюулгүй байдлын баталгаажуулалт буюу хяналт, технологи, хүний үйл явцыг тасралтгүй баталгаажуулах зэрэг шинэ механизмууд 2024-2025 онд тэргүүлэх ач холбогдолтой болсон байна[45].

Биологийн дархлааны системийн зарчмыг мэдээллийн технологид хэрэглэсэн хиймэл дархлааны системийн хувьд кибер дархлааны системүүд нь хүн болон амьтны дасан зохицогч дархлааны системийг дуурайлган шинэ, өмнө нь үл мэдэгдэх кибер халдлагыг илрүүлж, саармагжуулах чадвартай байдаг. Уламжлалт галт хана болон халдлага илрүүлэх системүүд өмнө нь тохиолдож байгаагүй халдлагыг илрүүлэхэд хүндрэлтэй байсан бол кибер дархлааны систем

[43]Kaspersky Lab. (2024a). Kaspersky Security System. KasperskyOS. https://os.kaspersky.com/technologies/kaspersky-security-system/
Kaspersky Lab. (2024b). Microkernel. KasperskyOS. https://os.kaspersky.com/technologies/microkernel/
[44] Gartner. (2022). What is a digital immune system and why does it matter? Gartner. https://www.gartner.com/en/articles/what-is-a-digital-immune-system-and-why-does-it-matter
[45]Gartner. (2024, February 22). Gartner identifies top cybersecurity trends for 2024. https://www.gartner.com/en/newsroom/press-releases/2024-02-22-gartner-identifies-top-cybersecurity-trends-for-2024

биологийн дархлаанаас санаа авсан технологиудыг ашиглан энэ хязгаарлагдмал байдлыг даван туулдаг[46] байна.

## Дүгнэлт

Кибер дархлааны онолын асуудал, дэлхийн жишиг хэрэглээ, Монгол Улсын кибер аюулгүй байдлын өнөөгийн байдал, хамгаалалтын механизмуудыг үндсэн дээр дараах дүгнэлтүүдэд хүрч байна.

Нэгдүгээрт, кибер дархлаа нь уламжлалт хамгаалалтын аргачлалуудын хязгаарлагдмал байдлыг даван туулах боломжийг олгодог шинэлэг үзэл баримтлал юм. Биологийн дархлааны системийг загвар болгосон энэхүү хандлага нь төрмөл аюулгүй байдал, тусгаарлалт, тасралтгүй хяналтын зарчмуудад тулгуурлан системүүдийг халдлагад тэсвэртэй болгож байна.

Хоёрдугаарт, дэлхийн хэмжээнд кибер халдлагын тоо, хохирлын хэмжээ жил ирэх тусам эрс өсч байгаа нь кибер дархлааны системийг нэвтрүүлэх зайлшгүй шаардлагыг тодорхойлж байна. Орчин үеийн нарийн төвөгтэй кибер аюул заналхийлэлтэй тэмцэхийн тулд нийтийн болон хувийн секторийн хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь цахим хөгжлийн үр шимийг хүн бүрт хүргэх чухал нөхцөл болж байна.

Гуравдугаарт, Монгол Улс GCI 2024 тайлангаар Tier-3 буюу "Бэхжиж буй" түвшинд үнэлэгдсэн нь кибер аюулгүй байдлын чиглэлд тодорхой ахиц гарсныг харуулж байгаа боловч техникийн чадавх, хүний нөөцийн бэлтгэл, олон улсын хамтын ажиллагааг цаашид бэхжүүлэх шаардлагатайг илэрхийлж байна.

Дөрөвдүгээрт, хиймэл оюун ухаан болон машин сургалтын технологийг кибер дархлааны системд нэгтгэх нь ирээдүйн кибер аюулгүй байдлын гол чиг хандлага болж байна. Кибер аюулгүй байдлын удирдагчид 2025 онд бизнесийн тасралтгүй байдал болон хамтарсан эрсдэлийн менежментийг чухалчилсан, илүү төвлөрсөн кибер аюулгүй байдлын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд анхаарлаа хандуулж байна.

## Судалгааны үр дүн

Дээрх дүгнэлтүүдэд үндэслэн Монгол Улсын хувьд дараах саналыг гаргаж байна: Кибер дархлааны үзэл баримтлалыг үндэсний кибер аюулгүй байдлын бодлогод тусгах, KasperskyOS зэрэг кибер дархлааны зарчимд суурилсан технологиудыг стратегийн дэд бүтцэд нэвтрүүлэх, хиймэл оюун ухаанд суурилсан аюул илрүүлэх системийг хөгжүүлэх, мөн кибер аюулгүй байдлын мэргэжилтнүүдийн тоог нэмэгдүүлэх чиглэлд хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх нь асуудлыг авч үзэх шаардлагатай юм.

---

[46] Kousalya, G., et al. (2023). Artificial immune systems in local and network cybersecurity: An overview of intrusion detection strategies. Advances in Computational Intelligence and Its Applications Journal. https://www.acigjournal.com/Artificial-Immune-Systems-in-Local-and-Network-Cybersecurity-An-Overview-of-Intrusion,184306,0,2.html
Stanton, C., Katz, G., & Song, D. (2024). Enhancing cybersecurity with artificial immune systems and general intelligence: A new frontier in threat detection and response. IEEE Access. https://www.researchgate.net/publication/383758233

## Эш татсан сурвалж, судалгааны бүтээлийн жагсаалт

[1] Kaspersky. (2022, November 23). What is cyber immunity, and how to build an operating system based on the concept? Kaspersky Blog. https://www.kaspersky.com/blog/how-to-create-cyberimmune-system/46314/

[2] DOI: 10.65902/tsats.2026.01.002 Experience and Lessons from Human security in the cyber environment: Risks and key protection issues

[3] Wlodarczak, P. (2017). Cyber immunity. In I. Rojas & F. Ortuño (Eds.), Bioinformatics and biomedical engineering (Lecture Notes in Computer Science, Vol. 10209, pp. 1-9). Springer. https://doi.org/10.1007/978-3-319-56154-7_19 https://doi.org/10.1007/978-3-319-56154-7_19

[4] Kaspersky, E. (2021, November 12). Transition from cybersecurity to cyber-immunity. IRISSCON 2021. Infosecurity Magazine. https://www.infosecurity-magazine.com/news/transition-cyber-immunity-kaspersky/

[5] Check Point Research. (2024). A closer look at Q3 2024: 75% surge in cyber attacks worldwide. Check Point Blog. https://blog.checkpoint.com/research/a-closer-look-at-q3-2024-75-surge-in-cyber-attacks-worldwide/

[6] Cobalt. (2024). Top cybersecurity statistics for 2024. https://www.cobalt.io/blog/cybersecurity-statistics-2024

[7] SentinelOne. (2024). Key cybersecurity statistics. https://www.sentinelone.com/cybersecurity-101/cybersecurity/cyber-security-statistics/

[8] Check Point Research. (2024). A closer look at Q3 2024: 75% surge in cyber attacks worldwide. Check Point Blog. https://blog.checkpoint.com/research/a-closer-look-at-q3-2024-75-surge-in-cyber-attacks-worldwide/

[9] Butt, U. A., Amin, R., Aldabbas, H., Garg, S., Alroobaea, R., & Almotiri, S. H. (2021). Industrial IoT, cyber threats, and standards landscape: Evaluation and roadmap. PMC

[10] Kaspersky Lab. (2025). What is cyber immunity? Kaspersky IT Encyclopedia. https://encyclopedia.kaspersky.com/glossary/cyberimmunity/

[11] Software Engineering Institute. (2024). DevOps case study: Netflix and the Chaos Monkey. Carnegie Mellon University. https://www.sei.cmu.edu/blog/devops-case-study-netflix-and-the-chaos-monkey/

[12] Allied Market Research. (2023). Digital immune system market size, share, competitive landscape and trend analysis report: Global opportunity analysis and industry forecast, 2023-2032. https://www.alliedmarketresearch.com/digital-immune-system-market-A77311

[13] International Telecommunication Union. (2024). Global Cybersecurity Index 2024. ITU. https://www.itu.int/epublications/publication/global-cybersecurity-index-2024

[14] State Great Khural of Mongolia. (2021a). Law on Cybersecurity. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390365491061

[15] State Great Khural of Mongolia. (2021b). Law on the Protection of Personal Data. https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/2024-04/biznesiyn_bayguullaguudad_zoriulsan_garyn_avlaga.pdf

[16] Ministry of Digital Development, Innovation, and Communications. (2024, October 10). Cybercrime caused 87.5 billion MNT in damages. https://mddc.gov.mn/eng/2024/10/19291/

[17] Zolbayar, Ch. (2024, January 15). Over 90,000 cyberattacks are detected in Mongolia each week. itoim.mn. https://itoim.mn/a/2024/01/15/society/yek

https://doi.org/10.1149/MA2024-01115mtgabs

[18] Ministry of Digital Development, Innovation, and Communications. (2025, January 29). In 2024, countermeasures were taken against 145 IP addresses affected by malicious code attacks. https://mddic.gov.mn/eng/2025/01/20833/
[19] National Center for Combating Cyber Attacks and Incidents. (2023). About Us. https://ncsirt.gov.mn/p/3
[20] Government of Mongolia. (2023, August 30). On the establishment of the "Public Center for Combating Cyber Attacks and Incidents" as a state budget enterprise. (Decision No. 319). https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760334026011
[21] Ministry of Digital Development, Innovation, and Communications. (2024a, September 18). Collaborating with JICA to train cybersecurity and drone specialists. https://mddc.gov.mn/mn/2024/09/18657/
[22] Ministry of Digital Development, Innovation, and Communications. (2025, February 19). Oxford: Mongolia needs to increase investment to ensure cybersecurity. https://mddic.gov.mn/eng/2025/02/21011/
[23] Kaspersky Lab. (2024a). Kaspersky Security System. KasperskyOS. https://os.kaspersky.com/technologies/kaspersky-security-system/
[24] Kaspersky Lab. (2024b). Microkernel. KasperskyOS. https://os.kaspersky.com/technologies/microkernel/
[25] Gartner. (2022). What is a digital immune system and why does it matter? Gartner. https://www.gartner.com/en/articles/what-is-a-digital-immune-system-and-why-does-it-matter
[26] Gartner. (2024, February 22). Gartner identifies top cybersecurity trends for 2024. https://www.gartner.com/en/newsroom/press-releases/2024-02-22-gartner-identifies-top-cybersecurity-trends-for-2024
[27] [Ousalya, G. et al. (2023). Artificial immune systems in local and network cybersecurity: An overview of intrusion detection strategies. Advances in Computational Intelligence and Its Applications Journal. https://www.acigjournal.com/Artificial-Immune-Systems-in-Local-and-Network-Cybersecurity-An-Overview-of-Intrusion,184306,0,2.html https://doi.org/10.60097/ACIG/162896
[28] Stanton, C., Katz, G., & Song, D. (2024). Enhancing cybersecurity with artificial immune systems and general intelligence: A new frontier in threat detection and response. IEEE Access. https://www.researchgate.net/publication/383758233